



ЗАВХАН СУМЫН ТАНИЛЦУУЛГА


Төрсөн нутгаас эх орон эхтэй, төрсөн нутгаа мэдэхээс
танин мэдэх их үйлс эхлэлтэй.

Завхан сумын түүхэн товчоо

- 1924.06.06-нд Сартуулын Цэцэн вангийн хошууны төлөөлөгчдийн анхдугаар хурлаар газар усны нэрээр нэрлэгдсэн 16 сум байгуулсны нэг нь “**Зогсоо уул**” сум байв.
- Энэ үеэс одоогийн Завхан сумын суурь тавигдсан.1930-аад оны үеэс Засаг захиргааны хуваарийг өөрчилж 13 аймагт хуваах зорилт тавих болсон.
- Засаг захиргааны хуваарийг бүрэн шинэчлэхэд Увс аймаг байгуулагдаж Зогсоо уул сум бүрэлдэхүүнд нь багтаж,1932 оноос **Завхан сум** хэмээн нэрлэгдэх болсон түүхтэй. Сумын төв нь Гуугийн сайр, Зогсоогийн ар зэрэг газруудаар нүүдэллэн байрлаж байгаад 1945 оны хавар Шарбулагт төвлөрч одоогийн Завхан сум болсон. Тус сум нь засаг захиргааны 4 багтай, 2015 онд түүхт 90 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлсэн.

Нутаг дэвсгэр, хил хязгаар

- Завхан сум нь Монгол орны баруун хойд хэсэгт Их нууруудын хотгорт оршдог бөгөөд 682.9 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй. Хамгийн өндөр цэг нь Гилбэн уулын дарцагт оргил, далайн түвшнээс дээш 1515 метр, хамгийн нам цэг нь Хяргас нуурын эрэгт 1028 метр оршдог.
- Тус сум нь хойд талаараа Увс аймгийн Наранбулаг, Малчин, зүүн болон зүүн хойд талаараа Хяргас, Цагаанхайрхан, баруун болон баруун хойд талаараа Өлгий, Ховд аймгийн Мянгад, баруун урд болон урд талаараа Ховд аймгийн Дөргөн, Завхан аймгийн Дөрвөлжин, зүүн урд талаараа Завхан аймгийн Ургамал сумуудтай тус тус хиллэдэг. Сумын нутаг нь газар зүйн мужлалаар говийн мужид хамаарах ба бүхэлдээ Хяргас нуурын хотгорт оршдог.



Цаг агаарын нөхцөл байдал

- Сумын нутаг бүхэлдээ говийн бүсэд багтдаг. Газар зүйн бүсийн хувьд Их нуруудын хотгорт нам доор хонхорт оршдог учир агаарын уруудах урсгал зонхилж эсрэг циклон үүссэн тогтвортой байрладаг. Өвлийн улиралд эсрэг циклон байрласнаар цаг агаар тогтуун салхигүй болж, шөнөдөө ихээхэн хүйтэрдэг учир тус суманд жилд дунджаар 90-110 хоног хүйтэн хадгалагдаж байдаг.

